



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 1307

Улаанбаатар хот

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.6 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйл, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Улаанбаатар смарт карт” ХХК-ийн хувьцаа эзэмшигч Бүгд Найрамдах Солонгос Улсын “Ти мони” ХК-ийн нийслэлд шилжүүлэх 55 хувийн хувьцаанд ногдох биет болон биет бус хөрөнгийг хүлээн авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2.Хөрөнгө хүлээн авах ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Д.Амгалан)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ

Д.Нямбаатар

Х.НЯМБААТАР

1725021324

4320S1354



၁၇။ ၁၈။ ၁၉။ ၂၀။ ၂၁။

3. මුළු නිදරණ න්‍යා තැබ්ගත් වේ ප්‍රාග්ධන ආච්චර් සහ නිකුත් වූ ඇතුළත් මෙම නිදරණ නිස්සාකී

ወጪ (፭፻ እስከ ፭፻፲፻) -፭፻ ዓይነት በኩል ተከተሉ ነው እና

2. මිනුම් පිළිගෙන වෙනුවේ 2025 නැවත් 06 ජූලි 30 නැවත් තුළ ඇත්තායි

ପ୍ରାଚୀ ମାତ୍ରାରେ 22.5 ଟଙ୍କା ମାତ୍ରାରେ ୨୦୯୮ ଟଙ୍କା ଲୋକାଶିଖାରେ ପାଇସନ୍ତାରୁଥିବାକୁ:

ନୀର୍ମାଣ ମାତ୍ର କିମ୍ବା କିମ୍ବା

$$\frac{\partial \phi}{\partial x} = \frac{\partial \phi}{\partial y}$$

~~Contra~~

ଶ୍ରୀମତୀ କିରାତ



ପାଇଁରେ  
କାହିଁବେ ଏବେ କାହିଁବେ କାହିଁବେ

7452030269

Нийслэлийн Засаг даргын 2025 оны  
дугаар сарын 10-ны өдрийн  
11/07/2025 дугаар захирамжийн  
хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Д.Амгалан	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга.
Гишүүд:	Ш.Алтансоёмбо	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гэрээ, эрх зүйн хэлтсийн дарга;
	Л.Эрдэнэбадрах	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга;
	Э.Баясгалан	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Нягтлан бодох бүртгэлийн ахлах мэргэжилтэн;
	Д.Отгонжаргал	Нийтийн тээврийн бодлогын газрын дарга;
	Б.Бадамдорж	Нийтийн тээврийн бодлогын газрын Санхүү, аж ахуйн хэлтсийн дарга;
	Г.Санчир	“Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ийн Хөрөнгийн менежментийн хэлтсийн захирал;
	Ж.Билгүүн	“Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ийн Хөрөнгийн менежментийн хэлтсийн инженер;
	Т.Эрхэмбаяр	“Улаанбаатар хотын хөгжлийн корпораци” ХК-ийн мэдээлэл, технологийн инженер;
	С.Сэргжаргал	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга;
	Т.Сайнзаяа	Цагдаагийн Ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын тоон ул мөр илрүүлэх чиглэлийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч /зөвшилцөнөөр/;
	Г.Оргил	Цагдаагийн Ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн Техникийн

		ашиглалтын хэлтсийн программ хангамж хариуцсан ахлах инженер, цагдаагийн хошууч /зөвшилцсөнөөр/;
P.Мөнхмишээл	Тагнуулын Ерөнхий газрын ажилтан /зөвшилцсөнөөр/;	
Т.Бүтэнбаяр	Тагнуулын Ерөнхий газрын ажилтан /зөвшилцсөнөөр/.	
Нарийн бичгийн дарга:	Г.Тэмүүжин	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн хяналт шалгалтын хэлтсийн дарга.